

САЛГА ХЭМЭЭХ ХОРОЛ МЭЙРЭНГИЙН ТУХАЙ ДОМОГ ЯРИА

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

Тэмдэглэлийн товч утга: 1800-гаад оны сүүлчээр төв Халхын нэгэн хошуунд мэйрэнгийн алба хашиж байсан Хорол гэгч хүний тухай хууч ярианаас энэхүү нийтлэлд товч өгүүлжээ.

Түлхүүр үг: Хорол, ноёнтон, Амар сайд, Ханд чин ван мэйрэнгийн яст.

XIX зууны сүүлийн хагаст Дайчин вангийн хошууны мэйрэнгээр ажиллаж байсан Хорол буюу салга мэйрэнгийн цэц билгийн тухай ард олны дунд олон сайхан хууч домог үлджээ. Түүнээс ганц нэгийг уншигч Танаа толилуулья.

1. Бичээч байхдаа тодорсон нь

Хорол хошуу тамгын бичээч байлаа. Тэрбээр дарга шүүх хуралд оролцохоор хошуу тамгын газар очтол үүдэнд нь нэг авгай уйлаад сууж байв. Тэрбээр Хорол бичээчид хандан зовлонгоо тоочжээ. Тэрээр:

- Нэг найран дээр миний хүү баахан хөлчүүрхэж баяны хүүтэй муудалцан, хүчтэй түлхтэл цаана нь байсан бие давхар эмэгтэйг дайрч, ургийг нь унагасан /үр зулбасан/ юм. Баян хүүгээ өмөөрч хошуу тамганд заргалдаж, хүний амь хөнөөсөн гэж хүүд минь цаазаар авах ял оногдуулах гэж байна гэжээ. Хорол:

- Аа, тийм үү. Би шүүн таслах хэрэгт шууд шийдвэр гаргах эрхгүй боловч, шүүх явцад асуулт тавьж оролцох эрхтэй. Тэгэхлээр би нэг асуулт тавьж мухардуулаад:

- Хүнээ ав гэнэ. Тэгэхлээр хоёр гарын нь хүлээсийг тас огтлоод аваад гараарай гэжээ.

Шүүх ажиллагаа эхэлж, ядуу эмэгтэйн хүүг буруутгах аястай хэрэг явдал өрнөж байтал Хорол бичээч:

- Энэ залуу хэний хэн гэдэг, хэдэн настай хүнийг хороосон юм бэ? гэж асуув. Хэн ч хариулт өгч эс чадан мухардаж байтал Хорол бичээч:

- Санамсаргүй явдлаас болж, ураг хөндөгдөж, хүн болоогүй юмны төлөө хүнийг цаазалдаг хаанахын ёс вэ? гээд зарга шүүгч түшмэл рүү хартал толгой дохиж байлаа. Хорол бичээч:

- Хүнээ ав гэлээ. Тэгэхэд нутгийн ардууд нөгөө авгайн хүүгийн хүлээсийг тас огтлон авч гарсан гэдэг. Чингээд Хорол удалгүй хошууны түшмэл болон дэвшчээ. Тэрбээр насан идэртээ гар нь чичирдэг болж, нас ахьсан хойноо бүр салгалдаг болсон учир Салга мэйрэн гэж алдаршчээ.

2. Амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол ...

Салга мэйрэн говийн нэгэн хошуунд хэрэг нийлээд буцаж явтал хот айлын гадаа хүмүүс цугларан, чанга чанга дуугаран маргалдаж байв. Салга мэйрэнг таньсан өвгөжөөр хүн:

- Та манай гэрт тавтай морилогтун! хэмээж цай идээ бариад:

- Саахалт айлын маань хүн манай хөрш айлын эзэнтэй тором булаацалдан, хэрүүл маргаан болоод байна. Мэйрэнтэн гуай Та шүүж, хэрүүл маргааныг тасалж өгнө үү! гэлээ. Салга мэйрэн:

- Хоёр тал гэрчтэй юү? гэж асуув. Маргалдагч хоёр:

- Тийм гээд хоёр гэрч нь аль аль талдаа гэрчилжээ. Тэгтэл мэйрэн:

- Хоёр ингийг шилийг нь даруулж, сөгдүүлж хэвтүүл. Надад нэг саваа авчирч өг гэлээ. Салга мэйрэн торомыг саваадаж эхлэв. Тэгтэл ингэний нэг нь торомныхоо зүг өвдгөөрөө мөлхөн тэмүүлжээ. Салга мэйрэн:

- Та хоёр төрсөн үрээ өмөөрдөг үү? гэж асуухад тэд:

- Өмөөрнө гэлээ. Салга мэйрэн:

- Тэгвэл төрсөн үрээ өмөөрөх сэтгэл адгуусанд ч байдаг юм шүү дээ гэв. Салга мэйрэн худал мэдүүлэг өгсөн гэрчид хандан :

- Амьд хүний гэрч болохоор үхсэн хүний дэр бол гэж энэ дээ гэж хэлсэн гэдэг.

3. Эхтэй амьтан эхийгээ дагадаг жамтай

Ядуу бүсгүй баян айлын бэр болоод нэг хүү төрүүлжээ. Гэрлэгч хоёр хоорондоо таарч тохирохгүй байсан учир гэр бүл салжээ. Хошуу тамгынхан баяныд хүүг нь өгөх шийдвэр гаргасан байна. Уг шийдвэрээ хариуцсан түшмэл ноёндoo дөнгөж танилцуулаад байлаа. Ноёнтон ч түүний саналыг дэмжих янзтай. Салга мэйрэн хошуу ноёндoo бараалхаж:

- Надад танд айлтгах зарга байна. Би нэг бухтай юм. Бухны маань үр төл Зүүн түрүү, Залуугаар дүүрэн байна. Үүнийгээ би цуглуулж авъя гэсэн юм гэв. Ноёнтон:

- Эхтэй амьтан эхийгээ дагадаг жамтай хэмээлээ. Салга мэйрэн:

- Сая танд На түшмэлийн танилцуулсан хэргийг ч мөн ингэж шийдэх нь зөв юм аа даа, ноёнтон гэхэд хошуу засаг инээмсэглээд:

- Мэйрэнтэн та тэр хэргийг шийдэх гэж л "нохойтож" яваа юм бий. Тэр жишгээр шийд, шийд гэжээ. Ингэж ядуу бүсгүй хүүгээ аварсан гэдэг.

4. Нутагтаа шингэж, эрдэмтэн мэргэд төрөг ...

Салга мэйрэн ендөр настай болж, албаа өгч, төрөлх Уулын голдоо ирж нутаглажээ. Бие нь чилээрхүү байх болж, хэвтэрт орсон аж. Үүнийг дуулсан Засаг ноён нэг түшмэлээ дуудан:

- За, чи Мэйрэнтэн гуайн амар мэндийг асууж, миний өмнөөс хадаг, 50 лангийн мөнгөн юмбүү бариад ир. Харин намайг гуйж байна гээд бийр янтайг нь аваад ирээрэй гэжээ. Элч түшмэл Уулын голын адаг хавиар нутаглаж байсан Мэйрэнгийнд очиж, ноёны айлтгасан ёсоор хадаг, юмбүүг барьж, түүний хүсэлтийг дамжуулав. Тэгтэл Салга мэйрэн бийр янтайгаа авдарнаасаа гаргаад хөгшиндөө хандан:

- Дээд тулганд гал дүрэлзтэл өрд гэлээ. Тэрбээр бийр янтайгаа хадганд сайтар ороож:

- Ноёнтон намайг мэйрэнгээс дээш гаргасангүй гэж гомдож гэж бодох байх даа. Гэхдээ яахав, насан турш нийлсэн бийр янтай минь нутагтаа шингэж үлдвэл хойшид энэ хавиас ухаант мэргэд олон төрөх болов уу хэмээн мунхагланам гэж хэлээд дүрэлзсэн гал руу бийр янтайгаа шидсэн гэдэг. Тэр цагаас хойш Бугат нутгаас Ханд чин ван, Амар сайд зэрэг олон мэргэд төрсөн ажээ.

5. Мэйрэнгийн ёст буюу яст гэхийн учир

Хорол аругай мэйрэн болоод төр ёсоо өөрийнхээ намаржаа, өвөлжөөнийхээ ойролцоо хийсэн учир тэр цагаас уг газрыг "Мэйрэнгийн ёст" гэж нэрлэх болсон бөгөөд харин түүний ертөнцийн мөнх бусыг үзүүлэхэд, тэр л нутагт нь шарилыг нь тавьсан учир сүүлдээ "Мэйрэнгийн яст" гэж нэрлэх болсон бүлгээ.

Abstract: This article is about a wise official named Khorol, who lived in one of the central Khalkha banners at the end of 1800's.